




НЭЭЛТТЭЙ  
НИЙГЭМ  
ФОРУМ

# ГАДААД ОРНУУДЫН ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙН СУДАЛГАА

Судлаач Б.Батхишиг, Хууль зүйн магистр



# АГУУЛГА

i.	СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА.....	3
ii.	СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ БА ХУРААНГУЙ .....	4
iii.	ГАДААД УЛС ОРНУУДЫН ОҮИТБС-ЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА .....	5
	A. Бусад улс орны ОҮИТБС-ын тухай хуулийн ерөнхий танилцуулга .....	5
	Б. Либер, Нигер, Норвеги улсын ОҮИТБС-ын тухай хуулиуд .....	7
	В. Европын холбоо, Англи, Америк, Канад улсын ОҮИТБС-ын тухай хуулиуд .....	15
	ЭХ СҮРВАЛЖ .....	22

# I. СУДАЛГААНЫ ТАНИЛЦУУЛГА

2002 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОҮИТБС буюу цаашид Санаачилга гэх) дэлхий дахинаа анх танилцуулагдсанаас хойшхи 10 гаруй жилийн хугацаанд дэлхийн 48 улс эл Санаачилгыг хэрэгжүүлэхээр нэгдэн ороод байгаагаас 31 нь "Хэрэгжүүлэгч улс" буюу Санаачилгын шаардлагыг хангасан улс гэсэн статусыг аваад байна. Эдгээрээс Либер, Нигер, Норвеги, Европын холбоо, Англи, Америк, Канад зэрэг улсууд энэ чиглэлээр бие даасан хууль батлан хэрэгжүүлж байна. Энэхүү харьцуулсан судалгаанд дээрх улс орны ОҮИТБС-ын тухай хуулиудын ерөнхий танилцуулгыг оруулснаас гадна хуулиудыг агуулгынх нь ижил төстэй байдлаар 2 бүлэг болгон 1-р хэсэгт нь Либер, Нигер, Норвеги улсууд<sup>1</sup>, 2-р хэсэгт нь Европын холбоо, Англи, Америк, Канад улсын хуулиудыг багтааж судаллаа.

Либер, Нигер, Норвеги улсуудын хуулийг судлахдаа манай улсад эрдэс баялгийн салбарт ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхтэй холбоотойгоор анхаарах гол асуудлуудыг харгалзан дор дурдсан бүтцээр харьцуулан судлав:

1. Хуулийн ерөнхий танилцуулга
2. ОҮИТБС-ын хэрэгжилтийг хариуцсан байгууллага
3. Олон талын оролцоот Ажлын хэсэг

<sup>1</sup> Эдгээр улсын хуулиудын судалгааг олон улсын Адам Смит Интернэшил байгууллагаас 2013 онд хийсэн "Хууль, эрх зүйн орчны дүн шинжилгээ, санал зөвлөмжүүд" баримт бичигт тулгуурлан хийсэн болно.

4. ОҮИТБС-ын тайланд нэгтгэл хийх үүрэг бүхий этгээдэд хамаарах журам
5. ОҮИТБС-ын тайлан гаргахтай холбоотой журам
6. Хариуцлагын зохицуулалт

Харин Европын холбоо, Англи, Америк, Канад улсын хуулиуд нь 1-р бүлэгт багтаасан улсуудын адил тодорхой бүтцийг агуулаагүй тул хуулиудынх нь заалт бүрээр харьцуулан доорх байдлаар судалсан болно. Үүнд:

1. Хуулийн ерөнхий танилцуулга
2. Тайлагнах үүрэг бүхий этгээд
3. Хэнд төлсөн төлбөрийг тайлагнах
4. Тайланд хамрагдах үйл ажиллагаа
5. Тайланд тусгах мэдээлэл
6. Төлбөрийн заавал тайлагнах доод хэмжээ
7. Тайлагнах хүрээ
8. Хэнд тайлагнах
9. Тайланг хүлээн авагчийн бүрэн эрх
10. Хараат бус аудит
11. Бусад улсын хууль тогтоомжийн дагуу гаргасан тайлангийн давхцал, зөрчилдөөн
12. Хариуцлагын зохицуулалт

## II. СУДАЛГААНЫ ДҮГНЭЛТ БА ХУРААНГУЙ

Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлыг хангах бие даасан хуультай Нигер, Либер, Норвеги улсуудын холбогдох хуулиуд нь ОҮИТБС-ын үндсэн зарчим, стандартууд (2011 болон 2013)<sup>2</sup> батлагдахаас өмнө буюу 2007 болон 2009 онуудад тус тус батлагдан гарсан байна. Нигер, Либер улсуудын хуулиуд нь бүтэц, агуулгын хувьд хоорондоо нилээд төсөөтэй бол Норвеги Улсын хууль нь зөвхөн газрын тос, байгалийн хийн салбарыг хамарсан товч агуулгатай байна. Дээрх улсын хуулиуд дахь Санаачилгыг хэрэгжүүлэхтэй холбоотой процессын нарийн зохицуулалтууд нь эрдэс баялгийн салбарын ил тод байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэхийг зорьж буй манай улсын хувьд судалгааны ач холбогдолтой юм.

2010-2014 онд Европын холбоо, Англи, Америк, Канад зэрэг улсууд нь олборлох салбар дахь төлбөр, орлогыг ил тод болгох асуудлаар хууль тогтоомж гарган хэрэгжүүлж эхлээд байна. Эдгээр улсын хуулиуд нь Санаачилгын шаардлагыг нэг бүрчлэн тусгаагүй боловч олборлогч компаниудад дотооддоо төлсөн төлбөр, орлогоос гадна үйл ажиллагаа явуулж буй гадаад улс орнуудын засгийн газарт төлсөн төлбөрөө ч тайлагнах үүргийг хүлээлгэнээрээ онцлог байна.

Дээрх улсуудын эрх зүйн тогтолцоо нь манайхаас өөр тул хууль тогтоомжийг нь шууд хуулбарлан хэрэгжүүлэх боловч Монгол Улс санаа авч болохуйц зарим тодорхой зохицуулалт байгааг дурдъя. Тухайлбал, Либер Улс нь олборлох салбарын ил тод байдал, түүний хамрах хүрээг сайтар томъёолон хуульчилсан (Олборлох салбар дахь гэрээний ил тод байдлыг бүрэн дэмжсэн) бол Нигер нь Санаачилгын хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор Санаачилгын зарчим, шаардлагыг зөрчсөн компани, албан тушаалтанд хүлээлгэх хариуцлагыг нилээд дэлгэрэнгүй хуульчилж, зөрчил гаргасан компанийн тусгай зөвшөөрлийт түдгэлзүүлэх, цуцлах хүртэлх бүрэн эрхийг Ерөнхийлөгчдөө олгосон байна. Мөн Канадад хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс Санаачилгын асуудлыг эрхэлсэн албан тушаалтандaa бичиг баримт болон компьютер дэх мэдээллийг шалгах зэрэг өргөн эрх мэдлийг олгожээ.

<sup>2</sup> ОҮИТБС-ын стандартууд нь 2011 онд анх батлагдаж, 2013 онд шинэчлэгдсэн болно.  
[http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/THE%20EITI%20STANDARD%202013\\_Mon\\_last.pdf](http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/THE%20EITI%20STANDARD%202013_Mon_last.pdf)

# III. ГАДААД УЛС ОРНУУДЫН ОҮИТБС-ЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

## A. БУСАД УЛС ОРНЫ ОҮИТБС-ЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Нигер Улс хамгийн анх буюу 2007 онд “Нигер Улсын олборлох салбарын ил тод байдлын санаачилгын тухай хууль”-ийг батлан гаргасан ба үүнээс хойш Либер болон Норвеги, Европын холбоо, Англи, Америк, Канад улсууд энэ чиглэлээр бие даасан хууль батлан хэрэгжүүлж байна.

Нигер болон Либер улсуудын хууль нь бүтэц, агуулгын хувьд ерөнхийдөө төстэй. Санаачилгыг хэрэгжүүлэгч Үндэсний байгууллага, түүнийг удирдлагаар хангах субъект болох олон талын оролцоот Ажлын хэсэг, нэгтгэл тайлан гаргагч хараат бус этгээдийн удирдлага, зохион байгуулалт, санхүүжилт, үүрэг хариуцлага, Санаачилгын тайлан, түүний нэгтгэлийг гаргах, зөрчилд хүлээлгэх хариуцлага зэрэг үндсэн асуудлуудыг тусгажээ. Харин Норвеги Улсын Газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас орж ирэх бэлэн мөнгөний урсгалын тайлагналт, нэгтгэлийн тухай 2009 оны хууль нь зөвхөн газрын тосны үйл ажиллагаанаас төлөх төлбөр, орлогыг тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулсан нэлээд товч бүтэцтэй байна.

Дээрх гурван улсын хуулийг харьцуулбал, Либер болон Нигер улсуудын хууль нь бүтэц, агуулгын хувьд хоорондоо төсөөтэй боловч арай сүүлд батлагдсаныхаа хувьд Либер Улсын хууль нь илүү системтэй, ойлгомжтой томъёологдсон байна.

Харин Европын холбоо, Англи, Америк, Канад улсуудын хууль нь агуулга, ил тод байдлыг хангах шаардлагын хувьд хоорондоо төсөөтэй байна. Тухайлбал, Компаниудад өөрийн улсдаа болон үйл ажиллагаа явуулж буй улс орныхоо засгийн газарт төлсөн төлбөрөө ил тод тайлагнах үүргийг хүлээлгэсэн. Ингэхдээ Америкаас бусад улс нь дээрх шаардлагыг зөвхөн томоохон хэмжээний компаниудад тавьжээ.

**Эдгээр улсын хуулиудын онцлогийг дурдвал:**

Либер Улсын хууль нь нэгд, Санаачилгад хамрагдах салбарыг нилээд өргөн хүрээнд буюу ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн олборлолтоос гадна хөдөө аж ахуй, ой мод ашиглах чиглэлийн үйл ажиллагааг хамруулан авч үзсэн, хоёрт, олборлогч компаниудын төлсөн төлбөр, орлогоос гадна олборлох салбарт хийсэн гэрээ, тусгай зөвшөөрлийн ил тод байдлыг бүрэн дэмжсэн онцлогтой байна. Тодруулбал, олборлох салбарт хийсэн гэрээ, концесс, тусгай зөвшөөрлийг олон нийтэд нээлттэй байхаар хуульчилсан төдийгүй (5-р зүйл), тэдгээр гэрээ, концесс нь хуулийн дагуу хийгдсэн эсэхэд болон байгалийн нөөц баялгаас орох орлогын хуваарилалтад хийсэн мониторинг, аудитын дүнг тайландаа тусгадаг. Гуравт, ОҮИТБС-ын тайланг гаргаж өгөөгүй, эсхүл өөр бусад байдлаар ОҮИТБС-ын шаардлагыг зөрчсөн компани, засгийн газрын байгууллагад хариуцлага тооцох бүрэн эрхийг ОҮИТБС-ыг хэрэгжүүлэгч байгууллагад олгосон байна.

Нигер Улс нь олборлох салбарын төлбөр, орлоготой холбоотой авлигын бүх хэлбэрийг устгах явдлыг Санаачилгыг хэрэгжүүлэгч Үндэсний байгууллагын үндсэн зорилгуудын нэг болгон тунхаглаж, улмаар Санаачилгын зарчим, стандартыг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг дэлгэрэнгүй хуульчилснаараа онцлогтой. Тийм ч учраас улсынхаа Ерөнхийлөгчид (Ажлын хэсгийн санал болгосноор) Санаачилгыг зөрчсөн компанийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах хүртэлх өргөн эрх мэдлийг олгосон байна.

Норвегийн хууль нь өмнө дурдсанчлан зөвхөн газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас орох төлбөр, орлогын ил тод байдлыг хангах асуудлыг зохицуулдаг. Газрын тосны асуудал эрхэлсэн яам нь Санаачилгыг хэрэгжүүлэх олон талт ажлын хэсгийг даргалах, баталгаажуулагчийг сонгох, тайлангийн маягтыг батлах зэрэг өргөн эрх мэдлийг хуулиар эдэлдэг байна.

Англи Улс нь Европын холбооны гишүүн болохын хувьд энэ улсын 2014 онд батлагдсан "Засгийн газарт төлсөн төлбөрийг тайлагнах тухай 3209 тоот журам нь бүхэлдээ Европын холбооны 2013 оны "Нягтлан бodoх бүртгэлийн болон ил тод байдлын тухай" тогтоолын 10-р бүлгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн байна. Эдгээр хуулийн дагуу Европын эдийн засгийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг, хувьцаагаа Европын хөрөнгийн зах зээл дээр арилжаалдаг нээлттэй компаниуд болон томоохон хэмжээний олборлогч компаниуд нь байгалийн баялаг ашиглах үйл ажиллагаанаасаа Европын холбоо болон Англи Улсад төлсөн төлбөрүүдээ ил тод болгохоос гадна үйл ажиллагаа явуулж буй улсынхаа засгийн газарт төлсөн төлбөрөө хүртэл ил тод тайлагнах үүргийг хүлээжээ. Гэхдээ дээрх шаардлагыг хангасан бүх компани төлбөр, орлогоо заавал тайлагнах үүрэг хүлээхгүй ба тухайн

жилд тогтоосон хэмжээнээс илүү төлбөр төлсөн компаниуд л ил тод байдлын тайлан гаргах үүрэгтэй байна. Тухайлбал, Европын холбооны улсад тайланда хамрагдах орлогын шалгуурыг 1000 еврогоор тогтоож өгчээ.

Канад Улсын хууль нь ОҮИТБС-ын хэрэгжилтийг хариуцах байгууллагын эрх хэмжээг дэлгэрэнгүй хуульчилснаараа онцлогтой. Харин АНУ нь олборлох салбарын төлбөр, орлогын ил тод байдлыг "Додд Франк Уолл Стрийтийн Шинэчлэл болон Хэрэглэгчийн Эрхийг Хамгаалах Тухай Акт"-ын 2010 онд батлагдсан нэмэлтээр зохицуулж байна. Энэхүү актын Англи, Канад зэрэг улсуудын хуулиас ялгагдах онцлог нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ болон засгийн газарт төлсөн төлбөрийн хэмжээнээс үл хамааран заавал тайлагнах үүргийг олборлох үйлдвэрлэл эрхлэгч бүх компаниудад хүлээлгэсэн явдал юм. 2013 онд бизнесийнхэн болон парламент дахь сөрөг хүчиний намынхан уг актыг хүчингүй болгох санал гаргаж байжээ.

Доорх хүснэгтэд эдгээр улс орны ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой хуулийн зохицуулалтуудыг дэлгэрэнгүй үзүүлэв. Хоосон хүснэгт нь тухайн асуудлыг хуулиар зохицуулаагүй үлдээсэн гэсэн үг болно.

## Б. ЛИБЕР, НИГЕР, НОРВЕГИ УЛСЫН ОҮИТБС-ЫН ТУХАЙ ХУУЛИУД

<b>Хуулийн нэр, батлагдсан огноо</b>	Либери Улсын Олборлох салбарын ил тод байдлын санаачилга (ЛОҮИТБС)-ыг зохион байгуулах тухай хууль, 2009	Нигери Улсын Олборлох салбарын ил тод байдлын санаачилга (НОҮИТБС)-ын тухай хууль, 2007	Газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас орж ирэх бэлэн мөнгөний урсгалын тайлагнант, нэгтгэлийн тухай хууль, Норвеги Улс, 2009
<b>Хуулийн бүтэц, зохицуулах асуудал</b>	<b>Нийт 9 бүлэгтэй:</b> Өмнөтгөл 1. Хуулийн нэр томъёо 2. ЛОҮИТБС-ыг үүсгэн байгуулах <sup>3</sup> 3. ЛОҮИТБС-ын зорилго 4. ЛОҮИТБС-ын бүрэн эрх 5. ЛОҮИТБС-ын хамрах хүрээ, чиглэл 6. ЛОҮИТБС-ын удирдлага 7. Тайлагнах 8. Санхүүжилт 9. Хууль хүчин төгөлдөр болох	<b>Нийт 22 зүйлтэй:</b> 1. НОҮИТБС-ыг үүсгэн байгуулах тухай <sup>4</sup> 2. НОҮИТБС-ын зорилго 3. НОҮИТБС-ын бүрэн эрх 4. Аудиторыг томилох 5-12. НОҮИТБС-ын Ажлын хэсгийн эрх хэмжээ, бүтэц, үйл ажиллагааны журам 13-15. НОҮИТБС-ын төсөв, санхүү 16-20. Хариуцлага хүлээлгэх, нэхэмжлэл гаргах 21. Хуулийн нэр томъёо 22. Хуулийн нэр	<b>Нийт 10 зүйлтэй:</b> 1. Зорилго 2. Тодорхойлолт 3. Төлсөн төлбөрийг тайлагнах 4. Хүлээн авсан орлогыг тайлагнах 5. Олон талт ажлын хэсэг 6. Зохицуулагч 7. Тайлан бэлтгэх 8. Баталгаажуулалт 9. Тайлангийн маягт, бусад заалтууд

<sup>3</sup> Цаашид "ОҮИТБС-ын хэрэгжилтийг хариуцсан байгууллага", эсхүл ОҮИТБС-ын байгууллага гэж ойлгоно уу.

<sup>4</sup> Цаашид "ОҮИТБС-ын хэрэгжилтийг хариуцсан байгууллага", эсхүл ОҮИТБС-ын байгууллага гэж ойлгоно уу.

## 1. ОҮИТБС-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАРИУЦСАН БАЙГУУЛЛАГА

### Ерөнхий тодорхойлолт Байгуулагдсан хэлбэр

ЛОҮИТБС нь засгийн газрын бие даасан, хараат бус агентлаг (хуулийн этгээдийн эрхтэй буюу хариуцлагаа өөрөө хүлээдэг).

Үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл:

- (1) Байгалийн нөөцийг ашигласнаас олох орлого-төсвийн ил тод байдал:
  - Төлбөр, орлогын тайланг тогтмол хэвлэх, нэгтгэн дүгнэх, аудит хийж, аудитын тайланг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд нийтэлнэ.
- (2) Олборлох үйлдвэрлэлийн гэрээ хэлэлцээрийн ил тод байдлыг хөхиүүлэн дэмжих:
  - Гэрээнүүд нь олон нийтэд нээлттэй байна.
  - Мод огтлох, газрын тос, ашигт малтмал олборлох, хөдөө аж ахуй болон бусад салбарт лиценз, зөвшөөрөл, концесс олгох, гэрээ байгуулах үйл явц нь хуулийн дагуу явагдсан эсэхэд хийсэн аудит, шалгалтын ил тод байдлыг хангана.

НОҮИТБС нь хараат бус байгууллага (хуулийн этгээдийн эрхтэй, хариуцлагаа өөрөө хүлээдэг).

Үйл ажиллагааны үндсэн зорилго, чиглэл:

- (1) Олборлогч компаниудаас засгийн газарт төлсөн төлбөрийн ил тод байдлыг хангах, засгийн газрын хүлээн авсан орлогын хариуцлагатай байдлыг баталгаажуулах, мониторинг хийх;
- (2) Төлбөр, орлогыг тайлагнах явцад гарч буй ...авлигын бүх хэлбэрийг устгах;
- (3) Орлогын хуваарилалт, ашиглалтын ил тод байдлыг хангах;
- (4) ОҮИТБС-ын зарчмуудын биелэлтийг хангах.

Жич: Энэхүү хууль нь зөвхөн газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас засгийн газарт орох мөнгөн хөрөнгийн урсгалыг зохицуулах зорилготой.

### ОҮИТБС-ын хэрэгжилтийг удирдлагаар хангах байгууллага

Олон талын оролцоот Ажлын хэсэг

Олон талын оролцоот Ажлын хэсэг

### Бүтэц, зохион байгуулалт

- ОҮИТБС-ын хэрэгжилтийг хангах байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг Ажлын алба хариуцдаг.
- Ажлын албаны дарга болон орлогчийг Ажлын хэсгээс томилно.
- Ажлын албаны ажилтнууд, зөвлөхүүдийг Ажлын албаны даргын санал болгосноор Ажлын хэсэг томилно.
- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг Ажлын хэсэг хариуцдаг.
- Ажлын хэсгийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь орон тооны ажилтан байна.
- Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг Ажлын хэсгийн санал болгосноор Ерөнхийлөгч томилно.
- Ажилтнууд болон зөвлөхүүдийг Ажлын хэсэг сонгон авдаг.

---

#### Хүлээх үүрэг

- ОҮИТБС-ын тайлангийн маягтуудыг боловсруулах, шинэчлэх;
  - Нэгтгэл тайлан, аудитын тайланг хэвлэн нийтлэх, олон нийтэд нээлттэй байлгах;
  - Засгийн газраас иргэд, компаниудад олгосон ой мод ашиглах, газрын тос, байгалийн хий, ашигт малтмал олборлох, хөдөө аж ахуй болон бусад салбарт лиценз, зөвшөөрөл олгосон шийдвэр болон концессын эрх олгосон гэрээний нэгдсэн санг бүрдүүлэх, сангийн мэдээллийг олон нийтэд нээлттэй байлгах;
  - ОҮИТБС-ын төлөвлөлт, хэрэгжилт, мониторинг, үнэлгээн дэх иргэний нийгмийн идэвхтэй, үр дүнтэй оролцоог дэмжих;
  - ОҮИТБС-ын байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг жил тутам бэлтгэн гаргах.
  - Компаниудыг ил тод нээлттэй байлгах, хариуцлагатайгаар тайлагнах суурь бүтцийг бий болгох;
  - Засгийн газраас олборлох салбарт хийсэн хөрөнгө оруулалт, түүний менежментын ил тод байдал, тогтмол тайлагнах зарчмыг хангах;
  - Орлогод аудит хийх, төлбөр болон хүлээн авсан орлогын үнэн зөв байдлыг тогтоох үүрэг бүхий хараат бус аудиторыг томилох;
  - Олборлогч компаниудаас засгийн газарт төлөх татвар, роялти, хүү, урамшуулал, торгууль, хураамж, бусад төлбөрийг хугацаандаа төлж буй эсэхэд хяналт тавьж, гүйцэтгэлийг хангуулах;
  - Компаниудын зүгээс засгийн газарт төлж буй төлбөрт мониторинг хийх үүрэг бүхий төрийн байгууллагуудын сүл талыг тодорхойлон, чадавхжуулах арга хэмжээ авах;
  - ОҮИТБС-ын нэгтгэл тайланг олон нийтэд зориулан хэвлэн нийтлэх. Ингэхдээ компанийн өмчлөх эрх, гэрээний үүрэгт хохирол учруулахгүй байх явдлыг эрхэмлэх.
  - Олборлогч компаниуд болон засгийн газрын хооронд газар олгох, төсөв зохиож, захиран зарцуулах, бараа бүтэгдэхүүн нийлүүлэх, худалдан авах, үйлдвэрлэлийн өртөг тодорхойлох зэрэг асуудлаар байгуулагдсан гэрээний үүргийн биелэлтэд бодитой үнэлэлт өгөх.
-

<b>Санхүүжилт</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвөөс санхүүждэг. Ажлын хэсгээс төсөв боловсруулж өргөн мэдүүлнэ.</li> <li>- Тусlamж, хөгжлийн түншүүдийн хандив болон бусад олон улсын байгууллагуудын санхүүжилт.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Улсын төсвөөс санхүүждэг. Ажлын хэсгээс өргөн мэдүүлсний дагуу Парламент төсвийг батална.</li> <li>- Тусlamж, хандив болон бэлэг</li> <li>- Төсвөө юунд зарцуулахыг хуулиар тодорхой зааж өгсөн.</li> </ul>
<b>Ажлаа тайлагнах</b>	Ерөнхийлөгч, хууль тогтоох байгууллага болон олон нийтэд тайлagnана.	Ерөнхийлөгч болон Парламентад тайлagnана. (Аудитаар баталгаажуулна).
<b>2. ОЛОН ТАЛЫН ОРОЛЦООТ АЖЛЫН ХЭСЭГ (ОҮИТБС-ЫН БАЙГУУЛЛАГЫГ УДИРДЛАГААР ХАНГАХ ҮНДСЭН ҮҮРЭГТЭЙ)</b>		
<b>Үүрэг, хариуцлага</b>	<ul style="list-style-type: none"> <li>- ЛОҮИТБС-ын Ажлын алба байгуулах (Албаны дарга, орлогч, зөвлөхийг томилох, чөлөөлөх), үйл ажиллагааны дүрэм журмыг батлах;</li> <li>- ЛОҮИТБС-ын ажлын төлөвлөгөөг боловсруулах, батлах, төсвийг батлах;</li> <li>- Аудит, шалгалт хийх, тайлангуудыг нэгтгэх үүрэг бүхий бие даасан зохицуулагч/аудиторыг томилох;</li> <li>- ЛОҮИТБС-ын тайланг батлах, хэвлэх эрх олгох;</li> <li>- ЛОҮИТБС-ын санхүүгийн болон худалдан авалтын бодлого, түүнчлэн ЛОҮИТБС-ын бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ил тод байдлыг хангахад шаардагдах бодлогыг боловсруулах, батлах;</li> <li>- ЛОҮИТБС-ын тайланг гаргаж өгөөгүй, эсхүл өөр бусад байдлаар ЛОҮИТБС-ын шаардлагыг зөрчсөн компани, засгийн газрын байгууллагад хүлээлгэх хариуцлагыг тодорхойлох.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ОҮИТБС-ыг хэрэгжүүлэх бодлого, хөтөлбөр, стратеги боловсруулах;</li> <li>- НОҮИТБС-ын үйл ажиллагааг зохицуулахад шаардагдах дүрэм, журам батлах;</li> <li>- ОҮИТБС-ын байгууллагын жилийн төсөв болон ажлын төлөвлөгөө боловсруулах, үйл ажиллагаанд нь тогтмол хяналт тавих.</li> </ul> <ul style="list-style-type: none"> <li>- ОҮИТБС-ын хэрэгжилтэд мониторинг, үнэлгээ хийх;</li> <li>- Нэгтгэл гаргагчийн бэлтгэсэн нэгтгэл тайланда санал өгөх;</li> <li>- ОҮИТБС-ын үйл ажиллагаанд баталгаажуулалт хийх этгээдийг сонгон шалгаруулахтай холбоотой саналыг Яаманд өгөх.</li> <li>- Тайлангийн маягтуудыг боловсруулах талаар Яаманд санал өгөх.</li> </ul>

<b>Бүрэлдэхүүн</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Төр, иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөл бүхий 15 буюу түүнээс дээш тооны гишүүнтэй.</li> <li>- Төрийн байгууллагын төлөөлөл: Сангийн сайд, Газар, Уул уурхай, Эрчим хүчний сайд, Ойн аж ахуйн хөгжлийн газрын дарга болон Үндэсний газрын тосны компанийн ерөнхийлөгч;</li> <li>- Иргэний нийгмийн 4 төлөөлөлтэй: Төлсөн авсанaa нийтэл эвсэл, Олборлох салбарын ажилчдын үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл;</li> <li>- Хувийн хэвшлийн 4 төлөөлөлтэй: Уул уурхай, ойн аж ахуй болон газрын тос, байгалийн хийн салбарын төлөөлөл.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг оролцуулсан 15 хүртэлх тооны гишүүнтэй:</li> <li>- Олборлогч компаниудын төлөөлөл</li> <li>- Иргэний нийгмийн төлөөлөл</li> <li>- Олборлох салбар дахь үйлдвэрчний эвлэлийн төлөөлөл</li> <li>- Олборлох салбарын мэргэжлийн шинжээчид</li> <li>- 6 бус нутгаас тус бүр нэг төлөөлөгч</li> <li>- Гүйцэтгэх нарийн бичгийн даргаас бусад гишүүд нь орон тооны бус байна.</li> <li>- Ажлын хэсэг нь бүрэн эрхийн хүрээнийхээ зарим асуудлаар тусгай хороо, хэлтэс байгуулан ажиллуулж болно.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хамгийн багадаа 5 гишүүнтэй байх ба гишүүн тус бүрийг орлох гишүүнийг сонгосон байна.</li> <li>- Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөлөл, мөн газрын тос, байгалийн хийн салбараас төрд төлж буй орлогын ил тод байдлын асуудлаар мэдлэг, мэдээлэлтэй, сонирхогч хувь хүмүүсийн төлөөлөл үүнд орно.</li> </ul>
<b>Ажлын хэсгийн дарга</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхийлөгчөөс томилогдсон Дарга болон хамтран даргалагч Ажлын хэсгийг удирдана.</li> <li>- Ажлын хэсгийн даргыг Ерөнхийлөгч томилно.</li> </ul>	Ерөнхийлөгчөөс томилсон Дарга.	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын тос, эрчим хүчний яамны төлөөлөл даргална.</li> <li>- Хaan томилно.</li> </ul>
<b>Хугацаа</b>	3 жил	4 жил	2 жил
<b>Нэмэлт тайлбар</b>	Ажлын хэсгийн гишүүд цалин авч болно. Ажлын хэсгийн хуралдааны журам болон нарийн бичгийн даргад тавигдах шаардлагыг хуулиар дэлгэрэнгүй зохицуулсан.		

### 3. ОҮИТБС-ын тайланд нэгтгэл хийх үүрэг бүхий этгээдэд хамаарах журам

- |                     |  |  |   |
|---------------------|--|--|---|
| <b>Хүлээх үүрэг</b> | <ul style="list-style-type: none"><li>- Төлбөр болон орлогын үнэн зөв байдалд аудит/ нэгтгэл хийх;</li><li>- Материаллаг концесс, гэрээ, лиценз болон бусад эрх олгох үйл явц нь хуулийн дагуу явагдсан эсэхэд аудит/шалгалт хийх;</li><li>- Нэгтгэл тайлан бэлтгэх;</li><li>- Байгалийн нөөц баялгийн ашиглалтаас олсон орлогын шударга хуваарилалтыг хангах үүднээс хууль, концесс болон гэрээний дагуу нутгийн иргэд, тодорхой бүлгүүдэд оногдох мөнгөн хөрөнгийн нөөцдө мониторинг хийж, тайланд тусгах;</li><li>- Процессын болон байгууллагын дотоод алдаа дутагдлыг тайлагнах болон гарч буй хийдэл, тооцооны алдаа, хуулийн зөрчил, татвараас зайлсхийх явдалд хяналт тавих.</li></ul> | <ul style="list-style-type: none"><li>- Ажлын хэсгийн баталсан журмын дагуу компаниудын Засгийн газарт төлсөн төлбөр болон Засгийн газрын хүлээн авсан орлогын тайланд аудит хийх;</li><li>- Нэгтгэл тайланг бэлтгэх;</li><li>- Тайланг НОҮИТБС-д хүргүүлэх.</li></ul> | <ul style="list-style-type: none"><li>- Төлбөр болон орлогод тулгалт хийн нэгтгэл гаргах;</li><li>- Нэгтгэл тайланг бэлтгэх, хэвлэн нийтлэх (Тайланг эцэслэхээс өмнө Ажлын хэсгээс санал авна);</li><li>- Тайлангаар илрүүлэн гаргасан төлбөр, орлогын зөрүүний шалтгааныг тодруулах.</li></ul> |
|---------------------|--|--|---|

Томилох этгээд Ажлын хэсэг

Ажлын хэсэг

Ажлын хэсэгтэй зөвшилцөний дагуу Хaan томилно.

### 4. ОҮИТБС-ын тайлан гаргахтай холбоотой журам

- |                     |  |   |  |
|---------------------|--|---|--|
| <b>Хамрах хүрээ</b> | <ul style="list-style-type: none"><li>- Ойн болон ашигт малтмалын нөөц ашиглахтай холбоотойгоор компаниудаас төлсөн төлбөр болон Засгийн газрын хүлээн авсан орлого;</li><li>- Концесс олгох болон гэрээ байгуулах үйл явц;</li><li>- ОҮИТБС-ын Ажлын хэсгийн үйл ажиллагааны тайлан;</li><li>- ОҮИТБС-д хамруулахаар Ажлын хэсгээс тодорхойлж, Засгийн газрын зөвшөөрсөн бусад салбарыг тайланд хамруулж болно.</li></ul> | <ul style="list-style-type: none"><li>- Татвар, роялти, ногдол ашиг, бонус, торгууль зэрэг төрд төлөх ёстой төлбөрүүд;</li><li>- Газрын тос, байгалийн хий болон бусад ашигт малтмалын үйлдвэрлэлийн зардал, борлуулалтын хэмжээ.</li></ul> | <p>Газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаанаас холбогдо хууль тогтоомжийн дагуу төрд төлөх төлбөрүүд.</p> |
|---------------------|--|---|--|

<b>Тайлагнах үүрэг бүхий этгээд</b>	Олборлогч компаниуд	- Олборлогч компаниуд - Засгийн газар	- Газрын тос, байгалийн хийн лиценз эзэмшигчид; - Петеро AS болон Statoil Hydro ASA (төрийн өмчит компаниуд); - Татварын алба; - Газрын тосны хэрэг эрхлэх газар; - Гааль болон онцгой татварын алба; - Төв банк.
<b>Нэгтгэл тайлан гаргагч</b>	Ажлын хэсэг хараат бус аудитын байгууллагатай хамтран нэгтгэл тайлан гаргана.	Нэгтгэл тайланг бэлтгэх хараат бус этгээд	Нэгтгэл тайланг бэлтгэх хараат бус этгээд
<b>Тайланг хүлээн авагч</b>		Парламент болон Ерөнхий аудитор	
<b>Тайланг хэвлэн нийтлэх субъект</b>	Ажлын хэсэг	Ажлын хэсэг	Нэгтгэл тайлан гаргагчийн бэлтгэн ирүүлсэн тайланд Ажлын хэсэг нэг сарын дотор тайлбар өгнө. Үүний дараа нэгтгэл тайлан гаргагч этгээд тайланг хэвлэнэ.

## 5. Хариуцлагын зохицуулалт

Авах  
хариуцлагын  
арга хэмжээ

ОҮИТБС-ын шаардлагыг зөрчсөн этгээдэд шүүхээс дараах шийтгэлийг оногдуулна:

- Торгох;
- Төлөх ёстой төлбөрийг нөхөн төлүүлэх;
- Компанийн удирдах болон төрийн байгууллагын ажилтанд 2 жил хүртэл хугацаагаар хорих ял ногдуулах.

Ажлын хэсгийн санал болгосны дагуу Ерөнхийлөгч зөрчил гаргагчийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, цуцлах эрхтэй. НОҮИТБС-ын нарийн бичгийн дарга болон Ажлын хэсгийн гишүүдийг албан тушаалын эрх, үүрэгтэй нь холбогдуулан гаргасан нэхэмжлэлтэй холбогдох мөнгөн төлбөрийн үүрэг хариуцлагаас чөлөөлнө. Харин албаны бүрэн эрхэд нь хамаarahгүй асуудлаас үүдсэн хариуцлагыг өөрсдөө хүлээнэ.

## В. ЕВРОПЫН ХОЛБОО, АНГЛИ, АМЕРИК, КАНАД УЛСЫН ОҮИТБС-ЫН ТУХАЙ ХУУЛИУД

	Европын холбоо <sup>5</sup>	Англи <sup>6</sup>	Канад <sup>7</sup>	АНУ <sup>8</sup>
<b>1. Хуулийн ерөнхий танилцуулга</b>	<p>ОҮИТБС-ын асуудал нь Европын Холбооны Парламентаас 2013 оны 6 дугаар сарын 26-ны өдөр баталсан “Нягтлан бодох бүртгэлийн болон ил тод байдлын тухай” тогтоолын 10-р бүлгээр зохицуулагддаг.</p> <p>Европын Холбоо нь АНУ-ын Додд Франк Уол Стрийтийн шинэчлэл ба Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Актаас санаа авч, “Олборлох салбарын ил тод байдлын арга хэмжээний тухай акт”-ыг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталжээ.</p> <p>ОҮИТБС-ын шинэ стандартад тулгуурлан Нягтлан бодох бүртгэл болон ил тод байдал гэсэн хоёр хэсэг бүхий энэхүү тогтоолыг баталжээ. Тогтоолоор Европын холбооны бүх гишүүн улсад нэгэн жигд стандарт тогтоосон.</p>	<p>Англи Улс нь Европын холбооны “Нягтланбодохбүртгэлийн болон ил тод байдлын тухай” тогтоолын 10-р бүлгийг хэрэгжүүлэх үүднээс 2014 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр “Засгийн газарт төлсөн төлбөрийг тайлагнах тухай 3209 тоот журам”-ыг батлан мөн оныхоо 12 дугаар сарын 1-ний өдрөөс мөрдөж эхэлжээ.</p>	<p>Канад Улс нь Европын холбоо болон АНУ-ын Додд Франк Уол Стрийтийн шинэчлэл ба Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Актаас санаа авч, “Олборлох салбарын ил тод байдлын арга хэмжээний тухай акт”-ыг 2014 оны 12 дугаар сарын 10-ны өдөр баталжээ.</p>	<p>Додд Франк Уол Стрийтийн Шинэчлэл болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай Актын 1504 дэх хэсэг (Байгалийн нөөц баялаг олборлогчоос төлсөн төлбөрийг ил тод болгох тухай асуудлыг зохицуулсан)-ийг 2010 онд баталсан.</p>

<sup>5</sup> <http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:32013L0034>

<sup>6</sup> Европын холбооны баталсан “Нягтлан бодох бүртгэлийн болон ил тод байдлын тухай” тогтоолын 10-р бүлгийн зохицуулалттай адил тул зөвхөн ялгаатай талуудыг нь дурдав. <http://www.legislation.gov.uk/ukssi/2014/3209/introduction/made>

<sup>7</sup> <http://www.parl.gc.ca/HousePublications/Publication.aspx?Language=E&Mode=1&DocId=6832421&File=464#27>

<sup>8</sup> [http://www.resourcegovernance.org/sites/default/files/Dodd-Frank%20bill\\_Sec%201504\\_0.pdf](http://www.resourcegovernance.org/sites/default/files/Dodd-Frank%20bill_Sec%201504_0.pdf)

## 2. Тайлагнах үүрэг бүхий этгээд

- Европын эдийн засгийн бүсэд үйл ажиллагаа явуулдаг компаниуд;
- Европын холбоонд хамаарах хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд болон ашигт малтмал, байгалийн хий, газрын тос болон ой мод ашиглах үйл ажиллагаа явуулдаг томоохон олборлогч компаниуд;
- Түүнчлэн хувьцаагаа нийтэд арилждаг хуулийн этгээд нь үйл ажиллагаа явуулдаг бүх улсынхаа засгийн газарт төлсөн төлбөрийг заавал тайлагнах үүрэгтэй.

Доорхи шалгуурын дор хаяж хоёрыг нь хангаж байгаа бол томоохон компани гэж үзнэ:

- тухайн үеийн санхүүгийн тайлан тэнцэл нь 20 сая европогоос дээш байх;
- тухайн үеийн санхүүгийн тайлан тэнцэлд бичигдсэн цэвэр мөнгөн эргэлт нь 40 сая европогоос дээш байх,
- 250-аас дээш тооны ажилтантай.

Дараах шалгуурыг хангасан нээлттэй болон хаалттай олборлогч компаниуд:

- Англи Улсад бүртгэлтэй;
- Томоохон хэмжээний, эсхүл хувьцаагаа нийтэд арилждаг хуулийн этгээд байх;
- Англи Улсад хөрөнгийн биржид бүртгэлтэй боловч тус улсын хуулийн дагуу байгуулагдаагүй олборлогч компаниуд тайлан гаргах үүрэг хүлээхгүй.

Доорх шалгуурын дор хаяж хоёрыг нь хангаж байгаа бол томоохон компани гэж үзнэ:

- тухайн үеийн санхүүгийн тайлан тэнцэл нь 18 сая паундаас дээш байх;
- тухайн үеийн санхүүгийн тайлан тэнцэлд бичигдсэн цэвэр мөнгөн эргэлт нь 36 сая паундаас дээш байх.

Канадад болон гадаад улс орнуудад ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаа явуулдаг, Канадын хөрөнгийн биржид бүртгэлтэй, эсвэл Канад Улсад бизнес эрхэлдэг болон бизнес эрхлэх байр, хөрөнгө эзэмшдэг, доорх шаардлагын хоёрыг нь (сүүлийн 2 жилийн аль нэг жилийн санхүүгийн тайландаа) хангаж чадах компаниуд заавал тайлагнах үүрэгтэй:

- 20 саяас дээш канад долларын өөрийн хөрөнгтэй;
- 40 сая буюу түүнээс дээш канад долларын жилийн орлоготой;
- 250-аас дээш тооны ажилтантай.

АНУ-д бүртгэлтэй ашигт малтмал, газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаа явуулдаг бүх компаниуд.

<b>3. Хэнд төлсөн төлбөрийг тайлагнах</b>	Европын холбооны гишүүн улсуудын засгийн газарт төлсөн төлбөр	Англи болон төлбөр төлсөн л бол аль ч орны засгийн газар	<ul style="list-style-type: none"> <li>- Канад болон аль ч улсын засгийн газарт төлсөн төлбөр;</li> <li>- Засгийн газар хоорондын байгууллага (авлигын эсрэг олон улсын байгууллага гэх мэт);</li> <li>- Засгийн газрын чиг үүргийг гүйцэтгэдэг байгууллага, бусад этгээд;</li> <li>- Нутгийн уuguул иргэдийн бүлэг (Энэхүү зохицуулалт нь эл акт үйлчилж эхлэх эхний 2 жилийн шилжилтийн хугацаанд мөрдөгднө.)</li> </ul>	Холбооны засгийн газар болон гадаад улсуудын засгийн газар
<b>4. Тайланд хамрагдах үйл ажиллагаа</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Ашигт малтмал, газрын тос, байгалийн хийтэй холбоотой үйл ажиллагаа;</li> <li>- Ой мод ашиглах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ашигт малтмал, газрын тос, байгалийн хийтэй холбоотой үйл ажиллагаа;</li> <li>- Ой мод ашиглах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ашигт малтмал, газрын тос, байгалийн хийтэй холбоотой үйл ажиллагаа</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Ашигт малтмал, газрын тос, байгалийн хийтэй холбоотой үйл ажиллагаа</li> </ul>
<b>5. Тайланд тусгах Мэдээлэл</b>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэлийн эрх;</li> <li>- Орлогын татвар;</li> <li>- Компанийн үйлдвэрлэл болон ашгийн мэдээлэл;</li> <li>- Роялти;</li> <li>- Ногдол ашиг;</li> <li>- Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурсны болон үр ашигтай нээлт тогтоосны, олборлолт эхэлсний урамшуулал, эзэмшлийн төлбөр;</li> <li>- Лицензийн болон түрээсийн төлбөр, аливаа лиценз, концесс, бусад эрхийн төлбөр;</li> <li>- Дэд бүтцийг сайжруулсны төлбөр.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэлийн эрх;</li> <li>- Орлогын татвар;</li> <li>- Компанийн үйлдвэрлэл болон ашгийн мэдээлэл;</li> <li>- Роялти;</li> <li>- Ногдол ашиг;</li> <li>- Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурсны болон үр ашигтай нээлт тогтоосны, олборлолт эхэлсний урамшуулал, эзэмшлийн төлбөр;</li> <li>- Лицензийн болон түрээсийн төлбөр, аливаа лиценз, концесс, бусад эрхийн төлбөр;</li> <li>- Дэд бүтцийг сайжруулсны төлбөр.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Хэрэглээний болон хувь хүний орлогын татвараас бусад татвар;</li> <li>- Роялти;</li> <li>- Түрээсийн болон эзэмшлийн төлбөр, хуулийн дагуу төлөх бусад төлбөр;</li> <li>- Лиценз, зөвшөөрөл, концессын бусад төлбөр;</li> <li>- Үйлдвэрлэлийн эрх;</li> <li>- Орлогын татвар;</li> <li>- Урамшуулал;</li> <li>- Энгийн хувьцаа эзэмшигчдэд төлснөөс бусад ногдол ашиг;</li> <li>- Дэд бүтцийг сайжруулсны төлбөр;</li> <li>- Хуулиар тодорхойлсон бусад төлбөр.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Үйлдвэрлэлийн эрх;</li> <li>- Орлогын татвар;</li> <li>- Компанийн үйлдвэрлэл болон ашгийн мэдээлэл;</li> <li>- Роялти;</li> <li>- Ногдол ашиг;</li> <li>- Бүтээгдэхүүн хуваах гэрээнд гарын үсэг зурсны болон нээлт, олборлолт эхэлсний урамшуулал, эзэмшлийн төлбөр;</li> <li>- Лицензийн болон түрээсийн төлбөр, аливаа лиценз, концесс, бусад эрхийн төлбөр;</li> <li>- Дэд бүтцийг сайжруулсны төлбөр.</li> </ul>

<b>6. Төлбөрийн заавал тайлагнах доод хэмжээ</b>	Санхүүгийн нэг жилд 100,000 евро ба түүнээс дээш хэмжээний нэг болон хэд хэдэн өөр төрлийн төлбөр төлсөн тохиолдолд тэдгээрийг заавал тайлагнана.	86,000 паунд	Санхүүгийн нэг жилд 100,000 канад доллар ба түүнээс дээш хэмжээний төлбөрийг нэг хүлээн авагчид төлсөн тохиолдолд заавал тайлагнана. Салбарын сайд журам гарган аль ч ангиллын төлбөрийн тайландаа хамрагдах доод хэмжээг өөрчилж болно.	Хязгаар байхгүй.
<b>7. Тайлагнах хүрээ</b>	Компаниуд нь засгийн газрын түвшинд төлснөөс гадна тухайн улсад хэрэгжүүлж буй төсөл тус бүрээс төлсөн төлбөрөө тайлагнана. Түүнчлэн үйл ажиллагаа явуулж буй улс тус бүрээр тайлан гаргана.	Адил	Адил	Адил
<b>8. Хэнд тайлагнах</b>	- Засгийн газар; - Гишүүн улсуудын холбогдох хуулиудад заасны дагуу олон нийтэд нээлттэй болгох.	Адил	- Салбарын сайд - Олон нийт	Үнэт цаасны комисст ирүүлэх тайландаа оруулан тусгана.

<b>9. Тайлан хүлээн авагчийн бүрэн эрх</b>	<p>Европын комисс нь "Нягтлан бодох бүртгэлийн болон ил тод байдлын тухай" тогтоолын 10-р бүлгийн хэрэгжилтийг хянах үүрэгтэй.</p> <p>Тайланг Европын комисс болон Зөвлөлд гаргаж өгнө.</p>	Засгийн газар	<p>ОҮИТБС-ын тайлангийн асуудал эрхэлсэн Сайдын бүрэн эрх:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Олборлох салбарын ил тод байдлын арга хэмжээний тухай актын хэрэгжилтийг хангах буюу тайлангийн асуудал хариуцах этгээдийг томилох;</li> <li>- Тайлангийн маягт батлах;</li> <li>- Тайлангаа ирүүлэхийг компаниас шаардах;</li> <li>- Хэрэв өөр улсын хуулийн дагуу гаргасан тайланг өөрийн улсынхтай нийцэж байна гэж үзвэл түүнийг нь хүлээн зөвшөөрөх;</li> <li>- Бусад улсын засгийн газартай энэ хуулийн хэрэгжилт, тэрхүү улсын тайлагналтын шаардлагын асуудлаар гэрээ байгуулах, тохиролцоо хийх;</li> <li>- Сайд болон түүний томилсон этгээд нь аж ахуйн нэгжийн байранд нэвтрэн орох, баримт бичгүүдийг шалгах, тайлан ирүүлэхийг шаардах, ирүүлсэн тайлан нь хуулийн шаардлагыг хангаж буй эсэхийг баталгаажуулахын тулд мэдээллийн сүлжээнд нь нэвтрэх эрхтэй.</li> </ul> <p>Тайлангийн асуудал хариуцсан албан тушаалтны бүрэн эрх (Сайд томилно):</p> <ul style="list-style-type: none"> <li>- Аж ахуйн нэгжийн байранд нэвтрэн орох, аливаа баримт бичиг, эд зүйлсийг шалгах, холбоо харилцааны хэрэгсэл, хэвлэх, хувилах төхөөрөмжийг ашиглах, компьютерийн сүлжээнд нэвтрэх, зураг авах, тоног төхөөрөмж зөөх зорилгоор ажилтнуудыг дайчлах, ажлын байрыг бүхэлд нь болон хэсэгчлэн хаах, шалгах зорилгоор аливаа зүйл, баримт бичгийг хураан авах;</li> <li>- Шаардлагатай тохиолдолд үүргээ гүйцэтгэхэд нь туслах хүнийг томилон авч явах;</li> <li>- Орон байранд нэвтрэхдээ өмчлөгчөөс, эсвэл холбогдох төрийн албан тушаалтнаас зөвшөөрөл авах.</li> </ul>	Үнэт цаасны комисс
--	---	---------------	---	--------------------

---

**10. Хараат  
бус аудит**

--

--

Тайлангийн үнэн зөв байдлыг  
хараат бус аудит, захидал, ажилтан,  
ня-бо зэрэг албан тушаалтнаар  
хянуулж, магадлан итгэмжлүүлсэн  
байна.

---

**11. Бусад  
улсын хууль  
тогтоомжийн  
дагуу  
гаргасан  
тайлангийн  
давхцал,  
зөрчилдөөн**

Компанийн өөр улсын хуулийн дагуу  
гаргасан тайланг өөрийн улсынхтай  
нийцэж байна гэж үзвэл тайлан  
гаргасантай адилтган үзэж болно.

Европын комисс нь компаниудын  
бусад улсын хуулийн дагуу гаргасан  
тайлан өөрийн улсын тайлангийн  
шаардлагатай нийцэж буй эсэхийг  
тодруулах, мөн үүнтэй холбоотой  
актуудыг батлан гаргана.

Компани энэхүү хуулийн үүргээ  
биелүүлснээр үйл ажиллагаа явуулж  
буй улсынхаа хууль тогтоомж болон  
байгууллагын нууц, бизнесийн  
гэрээгээ зөрчих эрсдэлд орох  
тохиолдолд энэхүү хуулийн дагуу  
ямар нэг баталгаа, эрх зүйн  
хамгаалалт эдлэхгүй.

---

Компанийн өөр улсын хуулийн  
дагуу тайлагнасан тайланг өөрийн  
улсынхтай нийцэж байна гэж үзвэл  
түүнийг нь Сайд хүлээн зөвшөөрөх  
ба компани нь өөр улсад  
тайлагнасан тайлангийн хувийг  
Сайдад хүлээлгэн өгнө.

**12. Хариуцла-  
гын  
зохицуулалт**

Тогтоолыг зөрчсөн явдалд хүлээлгэх хариуцлагын хэлбэр, хэмжээг тогтоох эрхийг гишүүн улсуудад нээлттэй үлдээсэн.

- ОҮИТБС-ын талуудаас гаргах тайлан болон нэгтгэл тайланд шаардагдах мэдээллийг хугацаанд нь ирүүлээгүй тохиолдолд мэдээлэл ирүүлэхийг шаардах, эсхүл тийнхүү ирүүлээгүйн шалтгааныг тайлбарлан шаардана. Цаашилбал, тайланг шаардан гаргуулж авах эрх бүхий этгээд болон компанийн төлөөлөгч (хувьцаа эзэмшигч зэрэг) нь тайланг 28 өдрийн дотор ирүүлэх шаардлага бүхий нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.
- Шаардсаны дагуу тогтоосон хугацаанд тайлан ирүүлээгүй, түүнчлэн тайланд хуурамч, буруу мэдээлэл тусгасан, худал мэдүүлсэн этгээдэд Ерөнхий прокурор болон улсын төрийн нарийн бичгийн даргын зөвшөөрөлтэйгөөр баривчлах, тorgох шийтгэл оногдуулна.

Хуулийн дагуу тайлагнаагүй, эсвэл худал буюу буруу тайлагнасан, тайлан гаргахаас зайлсхийсэн бол 250,000\$ хүртэлх хэмжээний торгууль ногдуулна. Зөрчлийг давтан гаргавал зөрчил тус бүрт нь хариуцлага оногдуулна.

# ЭХ СУРВАЛЖ

1. Нигери Улсын Олборлох салбарын ил тод байдлын Санчаачилгын тухай хууль, 2007  
<http://www.leiti.org.ir/uploads/2/1/5/6/21569928/act.pdf>
2. Либери Улсын Олборлох салбарын ил тод байдлын Санчаачилгыг үүсгэн байгуулах тухай хууль, 2009  
<http://www.neiti.org.ng/sites/default/files/documents/uploads/neitiact.pdf>
3. Газрын тосны үйл ажиллагаанаас орж ирэх бэлэн мөнгөний урсгалын тайлагналт, нэгтгэлийн тухай Норвеги Улсын хууль, 2009  
<http://www.ub.uio.no/ujur/ulodata/for-20090626-0856-eng.pdf>
4. Европын Холбооны Парламентын “Нягтлан бodoх бүртгэлийн болон ил тод байдлын тухай” тогтоолын 10-р бүлэг.  
<http://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=celex:32013L0034>
5. Засгийн газарт төлсөн төлбөрийг тайлагнах журам, 2014, №3209, Англи Улс  
<http://www.legislation.gov.uk/uksi/2014/3209/introduction/made>
6. Олборлох салбарын ил тод байдлын арга хэмжээний тухай акт, 2014, Канад Улс  
<http://www.parl.gc.ca/HousePublications/Publication.aspx?Language=E&Mode=1&DocId=6832421&File=464#27>
7. Додд Франк Уолл Стрийтийн Шинэчлэл болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай актын нэмэлт хэсэг 1504 (Нөөц баялаг олборлогчоос төлсөн төлбөрийг ил тод болгох тухай), АНУ  
[http://www.resourcegovernance.org/sites/default/files/Dodd-Frank%20bill\\_Sec%201504\\_0.pdf](http://www.resourcegovernance.org/sites/default/files/Dodd-Frank%20bill_Sec%201504_0.pdf)
8. Адам Смит Интернэшнл, Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны ОҮИТБС-ын хэрэгжилтийг дэмжих төсөл, “Хууль, эрх зүйн орчны дүн шинжилгээ, санал зөвлөмжүүд” 2013
9. ОҮИТБС-ын стандарт 2013 <[http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/THE%20EITI%20STANDARD%202013\\_Mon\\_last.pdf](http://www.eitimongolia.mn/sites/default/files/uploads/THE%20EITI%20STANDARD%202013_Mon_last.pdf)>
10. ОҮИТБС-ын цахим хуудас <[www.eiti.org](http://www.eiti.org)>